



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /2/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.08.25 № 44

танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Х.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	74,193,850.00	748,665,396.00
33	АВЛАГА	774,193,850.00	748,665,396.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	764,191,450.00	734,305,396.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	303,682,800.00	316,979,896.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	79,258,650.00	90,162,000.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	71,847,000.00	55,916,500.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	22,687,500.00	30,223,500.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	238,045,500.00	204,643,500.00
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	48,670,000.00	36,380,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,002,400.00	14,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	774,193,850.00	748,665,396.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	68,062,302.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,062,302.00	-
41300	Өглөг	69,500.00	-
41360	Бусад өглөг	69,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	69,500.00	-
41700	Хөтөлбөртэй холбоотой өглөг	67,992,802.00	-
41701	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	1,476,000.00	-
41702	Ажилд зуучлах	150,000.00	-
41703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	29,197,802.00	-
41705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	15,240,000.00	-
41707	Засгийн газар, ХӨҮЗ, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	294,000.00	-
41713	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ	(150,000.00)	-
41716	Нийтийг хамарсан ажил	20,485,000.00	-
41717	Ахмад мэргэжилтний зөвлөг үйлчилгээ	1,000,000.00	-
41718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	300,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	706,131,548.00	748,665,396.00
51	Засгийн газрын хувь оролцоо	706,131,548.00	748,665,396.00
51200	Хуримтлагдсан үр дүн	706,131,548.00	748,665,396.00
51210	Өмнөх үеийн үр дүн	706,131,548.00	705,198,648.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,466,748.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	774,193,850.00	748,665,396.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	665,769,244.00	1,541,386,390.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,223,144.00	747,489,038.00
1200	Өмчийн орлого	81,223,144.00	747,489,038.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,223,144.00	747,489,038.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	81,223,144.00	747,489,038.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	584,546,100.00	793,897,352.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	272,885,100.00	793,897,352.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,853,000.00	19,008,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	267,032,100.00	774,888,952.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	311,661,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	311,661,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	787,189,622.00	1,497,919,642.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	787,189,622.00	1,497,919,642.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,579,100.00	16,129,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	4,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	4,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,547,000.00	11,581,400.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,547,000.00	11,581,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	779,610,522.00	1,481,790,092.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,336,744.00	747,489,036.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,336,744.00	747,489,036.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,967,000.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	11,967,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	320,313,976.00	338,975,919.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,313,976.00	338,975,919.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	373,992,802.00	395,325,137.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	373,992,802.00	395,325,137.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(121,420,378.00)	43,466,748.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(121,420,378.00)	43,466,748.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	үлдэгдэл	-	-	706,131,548.00	-	706,131,548.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(932,900.00)	-	(932,900.00)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	705,198,648.00	-	705,198,648.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	43,466,748.00	-	43,466,748.00
16	үлдэгдэл	-	-	748,665,396.00	-	748,665,396.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	916,872,294.00	1,541,386,390.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332,326,194.00	747,489,038.00
1200	Өмчийн орлого	332,326,194.00	747,489,038.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	332,326,194.00	747,489,038.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	251,103,050.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	81,223,144.00	747,489,038.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	584,546,100.00	793,897,352.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	272,885,100.00	793,897,352.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,853,000.00	19,008,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	267,032,100.00	774,888,952.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	311,661,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	311,661,000.00	-
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	241,886,054.00
145	Бусад орлого (олз)	-	241,886,054.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	916,872,294.00	1,783,272,444.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,872,294.00	1,783,272,444.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,579,100.00	16,129,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	4,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	4,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,547,000.00	11,581,400.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,547,000.00	11,581,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	909,293,194.00	1,767,142,894.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,223,144.00	754,404,036.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,223,144.00	754,404,036.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,967,000.00	7,427,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	11,967,000.00	7,427,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	251,103,050.00	338,993,919.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	251,103,050.00	338,993,919.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	565,000,000.00	666,317,939.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	565,000,000.00	666,317,939.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	(241,886,054.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	241,886,054.00

145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	241,886,054.00
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	241,886,054.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөр, төслийн ангилал		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		ЗӨРҮҮ	
Код	Үзүүлэлт	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө
10	Оны эхний үлдэгдэл	-	-	-	-	-	-
101	Харилцахын эхний үлдэгдэл	-	-	-	-	-	-
102	Кассын эхний үлдэгдэл	-	-	-	-	-	-
11	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	-	705,989,002	3	1,783,272,444	(3)	(1,077,283,442)
112	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	-	697,989,002	-	774,888,952	-	(76,899,950)
1121	Үндсэн санхүүжилт	-	629,996,200	-	706,896,150	-	(76,899,950)
1122	Өмнөх оны өр барагдуулах санхүүжилт	-	67,992,802	-	67,992,802	-	-
113	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	-	-	-	19,008,400	-	(19,008,400)
115	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	-	8,000,000	3	747,489,038	(3)	(739,489,038)
118	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	-	-	241,886,054	-	(241,886,054)
2	ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН	4,370	716,992,402	4,584	1,783,272,444	(214)	(1,066,280,042)
21	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	2,023	15,156,000	2,023	14,495,237	-	660,763
211	Ганцаарчилсан	640	7,680,000	795	7,127,237	(155)	552,763
2111	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	640	7,680,000	795	7,127,237	(155)	552,763
212	Бүлгээр	1,383	7,476,000	1,228	7,368,000	155	108,000
2121	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /бүлгээр/	1,383	7,476,000	1,228	7,368,000	155	108,000
22	Ажилд зуучлах үйлчилгээ	880	6,160,000	1,032	6,160,000	(152)	-
222	Ажилд зуучлах үйлчилгээ	880	6,160,000	1,032	6,160,000	(152)	-
23	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	384	30,240,000	189	24,881,900	195	5,358,100
231	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	288	8,400,000	96	3,279,900	192	5,120,100
2311	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх	96	720,000	-	-	96	720,000

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2312	Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	96	2,880,000	96	2,880,000	-	-
2313	Ажлын байранд зуучлах уулзалтанд бэлтгэх	96	4,800,000	-	399,900	96	4,400,100
232	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах	96	21,840,000	93	21,602,000	3	238,000
2322	Танхимын сургалт зохион байгуулах	48	11,040,000	36	10,920,000	12	120,000
2323	Хоол унааны зардал	48	10,800,000	57	10,682,000	(9)	118,000
24	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	822	324,760,000	878	320,060,000	(56)	4,700,000
241	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	25	125,000,000	26	121,000,000	(1)	4,000,000
242	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах	82	2,460,000	82	2,460,000	-	-
2424	Аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах	82	2,460,000	82	2,460,000	-	-
243	Борлуулалтын дэмжлэг	-	9,300,000	-	9,300,000	-	-
245	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	15	75,300,000	15	75,300,000	-	-
2460	Нийтийг хамарсан ажил	400	112,000,000	755	112,000,000	(355)	-
2462	Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох - fintech	200	-	-	-	200	-
247	Цагийн ажилд зуучлах	100	700,000	-	-	100	700,000
25	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2	18,000,000	21	18,000,000	(19)	-
252	Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	2	18,000,000	21	18,000,000	(19)	-
2522	Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах	1	10,000,000	1	10,000,000	-	-
2523	Старт-Ап залуучуудад ментор хийх	1	8,000,000	20	8,000,000	(19)	-
26	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	11	11,080,000	11	10,080,000	-	1,000,000
261	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	2	10,000,000	2	9,000,000	-	1,000,000
262	Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	9	1,080,000	9	1,080,000	-	-
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	68	107,820,000	54	94,670,000	14	13,150,000
271	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээ	45	83,040,000	44	73,040,000	1	10,000,000
2711	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	1	10,000,000	-	-	1	10,000,000
2712	Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг /50 хувь эргэн төлөгдөх/	18	72,000,000	18	72,000,000	-	-
2716	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	26	1,040,000	26	1,040,000	-	-
272	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	4	10,080,000	2	10,080,000	2	-
2721	Ажил олгогчийн урамшуулал	4	10,080,000	2	10,080,000	2	-
273	ХБИ Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	12	12,600,000	8	9,600,000	4	3,000,000

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2731	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	12	12,600,000	8	9,600,000	4	3,000,000
274	Хөдөлмөр эрхэлтийн сургалт зохин байгуулах	7	2,100,000	-	1,950,000	7	150,000
2741	Танхимын сургалт зохион байгуулах	7	2,100,000	-	1,950,000	7	150,000
28	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	26	41,280,000	26	40,300,000	-	980,000
281	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	17	14,280,000	16	13,300,000	1	980,000
282	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	9	27,000,000	10	27,000,000	(1)	-
30	Хүүгийн хөнгөлөлт	2	700,000	-	-	2	700,000
301	Хүүгийн хөнгөлөлт	2	700,000	-	-	2	700,000
32	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	4,548,200	10	4,548,150	(10)	50
321	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	4,548,200	10	4,548,150	(10)	50
33	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	-	1,500,000	-	1,500,000	-	-
331	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	-	1,500,000	-	1,500,000	-	-
34	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	-	7,000,000	-	6,800,000	-	200,000
342	Програм хангамж, техник хангамжийн шинэчлэлт	-	-	-	3,000,000	-	(3,000,000)
343	Мэдээллийн сүлжээ түүний аюулгүй байдал	-	7,000,000	-	3,800,000	-	3,200,000
35	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3-н талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт	-	10,000,000	-	9,976,000	-	24,000
351	Сургалт зөвлөлгөөн /хэлтсийн өөрийн/	-	10,000,000	-	9,976,000	-	24,000
36	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	19,000,000	-	19,000,000	-	-
361	Сурталчилгаа зохион байгуулах	-	19,000,000	-	19,000,000	-	-
37	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	9,000,000	-	9,000,000	-	-
373	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	9,000,000	-	9,000,000	-	-
39	Гарын авлага хэвлэмэл материал	-	4,400,000	-	4,400,000	-	-
391	Гарын авлага хэвлэмэл материал хэвлэх, олшруулах	-	4,400,000	-	4,400,000	-	-
40	Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	-	2,000,000	2	4,002,000	(2)	(2,002,000)
404	ХЭД хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх чиглэлээр шинэ контент бүтээх, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг зорилтот бүлгийн	-	2,000,000	-	2,000,000	-	-

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	судалгаа мэдээлэл гэх мэт						
405	Хүүхэд хамгаалагч төсөл	1	2,352,000	2	2,002,000	(1)	350,000
41	ХЭЗҮ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийн санхүүжилт	-	15,000,000	-	15,000,000	-	-
50	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	149	19,003,400	59	11,581,400	90	7,422,000
501	Хөдөлмөр эрхлэлтийн цргц сургалт	59	10,873,400	59	10,873,400	-	-
50110	ХЗЗДТХ хэрэгжүүлэх чадавх бэхжүүлэх сургалтын зардал	59	10,873,400	59	10,873,400	-	-
502	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүгийн бус дэмжлэг	90	8,130,000	-	708,000	90	7,422,000
50201	Зээлийн өмнөх сургалт	70	840,000	-	708,000	70	132,000
50202	Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	20	4,790,000	-	-	20	4,790,000
50204	Бичил бизнес эрхлэгчдэд мэдээлэл зээл, санхүүгийн бус үйлчилгээний талаар мэдээлэл түгээх	-	1,000,000	-	-	-	1,000,000
50205	Бичил бизнес эрхлэгчдийн дэмжих арга хэмжээний хяналт, үнэлгээ	-	1,500,000	-	-	-	1,500,000
602	2020 онд үүссэн өр барагдуулах	2	67,992,802	275	66,571,000	(273)	1,421,802
6021	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ / өглөг /	-	1,476,000	-	1,476,000	-	-
60212	Бүлгээр / өглөг /	-	1,476,000	-	1,476,000	-	-
602122	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох /бүлгээр/ / өглөг /	-	1,476,000	-	1,476,000	-	-
6024	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр / өглөг /	-	48,555,000	264	48,555,000	(264)	-
60241	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/ / өглөг /	-	3,000,000	3	3,000,000	(3)	-
60244	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт / өглөг /	-	4,830,000	17	4,830,000	(17)	-
60245	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ / өглөг /	-	20,240,000	4	20,240,000	4)	-
602460	Нийтийг хамарсан ажил / өглөг /	-	20,485,000	240	20,485,000	(240)	-
6025	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр / өглөг /	-	300,000	1	300,000	(1)	-
60253	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт / өглөг /	-	300,000	1	300,000	(1)	-
6027	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр / өглөг /	-	15,240,000	9	15,240,000	(9)	-
60271	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээ / өглөг /	-	6,060,000	7	6,060,000	(7)	-
602712	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/ / өглөг /	-	5,000,000	4	5,000,000	(4)	-

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

602714	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт / өглөг /	-	1,060,000	3	1,060,000	(3)	-
60272	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ / өглөг /	-	9,180,000	2	9,180,000	(2)	-
602721	Ажил олгогчийн урамшуулал / өглөг /	-	9,180,000	2	9,180,000	(2)	-
6028	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр / өглөг /	-	1,000,000	1	1,000,000	(1)	-
60281	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ / өглөг /	-	1,000,000	1	1,000,000	(1)	-
6030	Хүүгийн хөнгөлөлт / өглөг /	-	1,127,802	2	1,127,802	(2)	-
60301	Хүүгийн хөнгөлөлт / өглөг /	-	1,127,802	2	1,127,802	(2)	-
6040	Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт / өглөг /	-	-	2	294,000	(2)	(294,000)
60405	Хүүхэд хамгаалагч төсөл / өглөг /	2	294,000	2	294,000	-	-
61	Төвлөрүүлэлт	-	-	-	1,100,824,955	-	(1,100,824,955)
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Төв сан	-	-	-	234,971,056	-	(234,971,056)
6112	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Сангийн яам	-	-	-	6,914,998	-	(6,914,998)
6120	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Төв сан	-	-	-	747,489,036	-	(747,489,036)
6122	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Сангийн яам	-	-	-	2	-	(2)
6130	Санхүүжилтын буцаалт - Төв сан	-	-	-	104,004,863	-	(104,004,863)
6132	Санхүүжилтын буцаалт - Сангийн яам	-	-	-	18,000	-	(18,000)
6142	Бусад төвлөрүүлэх шилжүүлэг - Сангийн яам	-	-	-	7,427,000	-	(7,427,000)
9	Эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-
91	Харилцахын эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-
92	Кассын эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(47,652,000.00)
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(47,652,000.00)
300015	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(47,652,000.00)
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	-	793,879,352.00
80110	Гадаад зээл, тусламжийн ТЕЗ-д шилжих ажил үйлчилгээ	-	11,581,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	11,581,400.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,581,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	11,581,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,581,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11,581,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	19,008,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,008,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	-	19,008,400.00
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	-	4,548,150.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,548,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,548,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,548,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,548,150.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,548,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,548,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	4,548,150.00
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	-	777,749,802.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	777,749,802.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	666,317,939.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	666,317,939.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	666,317,939.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	666,317,939.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111,431,863.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	111,431,863.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	817,974,802.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	47,634,000.00
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх	-	(18,000.00)
300015	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	47,652,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	770,340,802.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	770,340,802.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/137 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлт, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах Монгол хүний амьдралын чанарыг сайжруулах зорилго бүхий сан юм.

Тэргүүлэх чиглэл:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулах,
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь захиргаа хяналтын хэлтэстэй бөгөөд ХЭДСангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлдэг байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 705,989.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,589.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,942.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,528.4 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Авлага	774,193.8	748,665.4	(25,528.4)
Нийт хөрөнгө	774,193.8	748,665.4	(25,528.4)
Өр төлбөр	68,062.3	0	(68,062.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	706,131.5	748,665.4	42,533.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	774,193.8	748,665.4	(25,528.4)

Өмнөх оны өр төлбөрийг барагдуулж тайланд онд өглөг үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 748,665.4 мянган төгрөг болж 42,533.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 875,617.1 мянган төгрөгөөр буюу 131.5 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 710,730.0 мянган төгрөгөөр буюу 90.3 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 950,344.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 950,344.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 208,455.0 мянган төгрөгөөр бууруулан 741,889.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж 35,900.0 мянган төгрөгөөр бууруулж, 705,989.0 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн санхүүжилтийн дүнг бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ХЭДС-аас 706,896.1 мянган төгрөг, өмнөх оны өр барагдуулах санхүүжилт 67,992.8 мянган төгрөг, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж 19,008.0 мянган төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 747,489.0 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 241,886.1 мянган төгрөгийн орлого төвлөрч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 682,447.5 мянган төгрөгийг зарцуулж, 1,100,824.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 682,447.5 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь ажил үйлчилгээний чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээний зардлыг 660.8 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн зардлыг 5,358.1 мянган төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зардлыг 4,700.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлыг 1,000.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр 13,150.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 980.0 мянган төгрөг, бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах зардлыг 200.0 мянган төгрөг хөдөлмөрийн салбарын ажилтнуудын зардлыг 24.0 мянган төгрөг, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн зардлыг 7,422.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Олон улсын байгууллагаас сургалт зохион байгуулах зардалд 11,581.4 мянган төгрөг болон ХЭДСангийн зөвлөлийн зардалд зарцуулах 4,548.2 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2021 онд нийт 1,689,004.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 1,689,004.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, 125,250.8 мянган төгрөгийн 5 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй, хугацаа хэтэрсэн авлагыг бүрэн барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,298.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 22,419.39 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлт бүрэн

хангагдаагүй байна. Хугацаа хэтэрсэн зээлийг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ч зээл бүрэн төлөгдөөгүй байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	1	13,298.4		10,935.45	1	2,362.95	17.8
Зөвлөмж	1	22,419.39		9,715.5	1	12,703.8	56.7
Нийт дүн	2	35,717.79		20,650.95	2	15,066.75	42.2

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олголтыг үзэх шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 175,286.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19,932.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 30,103.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 125,250.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 10,002.4 мянган төгрөгөөр барагдаж, өмнөх оны өглөг 9,069.5 мянган төгрөгөөр буурсан тул зөрүү 932.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүн рүү залруулж тайлагнуулав,

- Авлагыг 19,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэж, үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны үр дүнг бууруулан тайлагнасныг залруулж тайлагнуулав.

4.3 Албан шаардлага

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн ч зөвлөмж бүрэн хангагдаагүй, 24 иргэний 30,103.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны 125,250.8 мянган төгрөгийн 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	30,103.0					1	30,103.0		
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	125,250.8							1	125,250.8
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	19,000.0	1	19,000.0						
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	932.9	1	932.9						